

ШУДАРГА ШИЛЖИЛТ БА ХҮНИЙ ЭРХ

НҮБ-ЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН НЭГДСЭН
ТАЙЛАНД ЗОРИУЛАН ХҮНИЙ ЭРХИЙН ДЭЭД КОМИССАРЫН
ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ МЭДЭЭЛЭЛ



ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



АГУУЛГА

1.	ТАНИЛЦУУЛГА	3
2.	ШУДАРГААР ШИЛЖИХ САНХҮҮЖИЛТИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГА	3
2.1	<u>Уур амьсгалын санхүүжилт, түүний дотор шударгаар шилжих санхүүжилт, олон улсын санхүүгийн тогтолцоог шинэтгэх нь</u>	4
	Зөвлөмж	5
2.2	<u>Бохидуулсан нь төлөх зарчим, түүнийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх арга хэмжээ</u>	6
	Зөвлөмж	6
2.3	<u>Даян дэлхийн татварын конвенцийг дэмжих нь</u>	6
	Зөвлөмж	7
2.4	<u>Шударга шилжилтийн явцад ажиллах хүчнийг хамгаалах түгээмэл нийгмийн хамгааллын тогтолцоо болон дэлхийн сангийн хэрэгцээ</u>	7
	Зөвлөмж	8
2.5	<u>Уур амьсгалын технологийн хүний эрхэд суурилсан хандлага</u>	9
	Зөвлөмж	9
2.6	<u>Оюуны өмч, худалдаа, хүний эрх</u>	9
1.6.1	Зөвлөмж	10
	ХАВСРАЛТ: ШУДАРГА ШИЛЖИЛТИЙН ШАЛГАХ ХУУДАС	11

1. ТАНИЛЦУУЛГА

Шударгаар шилжих, хүн бүр эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломж, шилдэг туршлага, хэрэгжүүлж болохуйц шийдэл, сорилт, хүндрэл бэрхшээлийн талаар Ерөнхий нарийн бичгийн дарга тайлан нэгтгэн боловсруулахад өөрийн байр суурийг хүргүүлэх¹ урилгыг Эмнести Интернэшнл талархан хүлээн авч байна.

Нүүрстөрөгч ялгаруулдаггүй эдийн засагт шударгаар шилжих нь бүхий л салбарт, хүний эрхийн өргөн хүрээнд, эрх эдлэгчдэд нөлөөлж байна. Тухайлбал ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхээс гадна эдийн засаг, нийгэм, соёлын эрх, тэр дундаа хөдөлмөрлөх, зохистой хөдөлмөрийн нөхцөлд ажиллах; бохирдолгүй орчин зэрэг эрүүл мэндийн эрх; нийгмийн хамгаалал; шаардлагад нийцсэн орон байр; ус; ариун цэвэр; зохистой хоол гэх мэт цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах эрхийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлдөг. Түүнчлэн шударга шилжилтийн нөлөөлөлд өртсөн хүн бүрийг зохистой хөдөлмөр, хангалттай амьжиргааны түвшинд хүрэх боломжийг бүрдүүлэхийн тулд сурч боловсрол эзэмших эрхийг хангах шаардлагатай. Иргэний болон улс төрийн эрх, тухайлбал оролцоо болон зөвлөлдөх эрх; үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх (мэдээлэл олж авах, худал болон төөрөгдүүлсэн мэдээлэлтэй тэмцэх); эвлэлдэн нэгдэх, тайван хуран цуглах эрх чөлөө; зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрх ч үүнд мөн адил багтана. Улс орнууд эдгээр эрхийг хамгаалах, хүндэтгэх, бүрэн хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд бизнесийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаанд хүний эрхийг хүндэтгэх үйл ажиллагааг зохицуулах асуудал бас хамаарна.

Эмнести Интернэшнл нь Олон улсын хөдөлмөрийн байгууллага² зэрэг байгууллагуудаас боловсруулсан удирдамжид тулгуурлан, засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагууд шударга шилжилтийн бодлого, төлөвлөгөөний хүний эрхийн нийцлийг үнэлэхэд туслах зорилгоор шалгах хуудас (checklist)-ыг боловсруулан энэхүү мэдээлэлд хавсаргасан.

2. ШУДАРГААР ШИЛЖИХ САНХҮҮЖИЛТ БА ХҮНИЙ ЭРХИЙН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГА

Улс орнууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтцийн болон эдийн засгийн өөрчлөлтөд хүрэхийн тулд урьд өмнө байгаагүй их хэмжээний нөөцийг дайчлах хэрэгтэй байна.³ Эдгээр нөөцийг (а) улс орнууд өөрсдийн нутаг дэвсгэрийн хүрээнд (татвар ногдуулах, түүнчлэн татвараас зайлсхийх, зугтах, үрэлгэн байдал, авлигын асуудлыг шийдвэрлэх замаар); (б) Дэлхийн банк, Олон улсын валютын сан зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламжаар (ихэвчлэн зээл хэлбэрээр); (в) олон улсын хамтын ажиллагаа, зээл тусламжаар бүрдүүлдэг. Чинээлэг улс орнууд уур амьсгалын хямралын шалтгаанд хариуцлага хүлээх үүднээс өөрсдийн чадавхи, боломж, санхүүгийн эх үүсвэр, технологийг дамжуулах ажлыг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

¹ <https://www.ohchr.org/en/calls-for-input/2024/call-inputs-just-transition-and-human-rights>

² The 2015 ILO Guidelines for a Just Transition Towards Environmentally Sustainable Economies and Societies for All provided a vision and a framework for a just transition that is widely accepted by trade unions, employers and governments, providing a systemic and whole-of- economy approach to sustainability that addresses environmental, social and economic issues together. Available at ILO, *Guidelines for a just transition towards environmentally sustainable economies and societies for all*, 20 February 2016, https://www.ilo.org/global/topics/green-jobs/publications/WCMS_432859/lang-en/index.htm

³ Article 2(1) of the International Covenant on Economic, Social and Cultural Rights. "Maximum available resources" are generally understood as resources that governments can realize and include human, technological and information resources, as well as financial resources.

Чулуужсан түлшнээс нүүрстөрөгчгүй эдийн засагт шилжих шударга шилжилтийг бүхэлд нь санхүүжүүлэх нь одоогоор Парисын хэлэлцээрийн дагуу уур амьсгалын санхүүжилтийн нэг бүрэлдэхүүн хэсэг болж чадаагүй байна.⁴ Шударга шилжилтийн зарим асуудал нь нөлөөллийг бууруулах, дасан зохицох гэсэн бүлэгт багтах боловч шударга шилжилтийн ажиллах хүчний зардал гэх зэрэг дээрх ангиллын аль алинд нь хамаарахгүй нэмэлт зардал гарах магадлалтай. Үүнд, чулуужсан түлш болон холбогдох үйлдвэрүүдийн шилжилтийн нөлөөлөлд өртсөн ажилчид, иргэдийн нийгмийн хамгааллын зардал; нөлөөлөлд өртсөн ажилчдад боловсрол олгох, давтан сургах; чулуужсан түлшний үйлдвэр, дэд бүтэц, нүүрстөрөгчийн эрчимжсэн үйлдвэрүүдтэй холбоотой бохирдол болон бусад байгаль орчны доройтлыг сэргээх байгаль орчны цэвэрлэгээний зардал зэрэг хамаарна. Улс орнууд шударга шилжилтийн төлөвлөлтөд уур амьсгалын санхүүжилт болон бусад хэлбэрийн тогтвортой хөгжлийн санхүүжилтийн тооцоонд шаардагдах зардлын үнэлгээг багтаасан байх ёстой.

1.1.1 Зөвлөмж

- Чинээлэг улс орнууд шударга шилжилтийг хангах, нөлөөлөлд өртсөн бүх хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэхийн тулд зохистой нөөцөөр хангах үүрэг хүлээх шаардлагатай.
- Олон улсын хамтын ажиллагаа, тусламж шаардлагатай улс орнууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг эрэлхийлэх ёстой.
- НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц болон Парисын хэлэлцээрийн талууд уур амьсгалын санхүүжилтийн зорилт, хэрэгжилтэд шударга шилжилтийн санхүүжилтийн бүх бүрэлдэхүүн хэсгийг тусгах шаардлагатай.

2.1 УУР АМЬСГАЛЫН САНХҮҮЖИЛТ, ТҮҮНИЙ ДОТОР ШУДАРГААР ШИЛЖИХ САНХҮҮЖИЛТ ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ТОГТОЛЦООГ ШИНЭТГЭХ НЬ

Өнөөгийн тогтолцоонд нүүрлээд байгаа тэгш бус байдлыг арилгах, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх замаар уур амьсгалын шударга ёсыг хангах, олон улсын хамтын ажиллагаа, тусалцаа үзүүлэх олон улсын үүрэг хариуцлагыг биелүүлэхийн тулд дэлхийн хөгжлийн санхүүжилт, татвар, төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагаанд өргөн ашиглах шаардлагатай байна.⁵

Өнөөгийн уур амьсгалын санхүүжилтийн дийлэнх хувь зээлийн санхүүжилт хэлбэрээр олгогдож байгаа нь хүлээн авагч орнуудын өрийг өндөр, тогтворгүй түвшинд хүргэж, улмаар өрийн дарамтнаас шалтгаалан уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд хүний эрхийг сулруулах төсвийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхээс өөр аргагүйд хүргэж байна.⁶ Өрийн хямрал нь орлого багатай орнуудын төсвийн боломжийг хязгаарлаж, Парисын хэлэлцээрийн зорилгод нийцсэн уур амьсгалын санхүүгийн урсгалыг нэмэгдүүлэхэд саад учруулж байна.

⁴ Article 9.1 of the Paris Agreement only requires the provision of finance to lower income countries for mitigation (including support for renewable energy infrastructure) and adaptation

⁵ See for example, Amnesty International, *Recommendations to states to finance economic, social and climate justice*, 5 June 2023, <https://www.amnesty.org/en/documents/ior10/6825/2023/en/>.

⁶ See for example Amnesty International, *Multiple Crises, Fiscal Systems and Human Rights: Submission to the Independent Expert on Foreign Debt, Other International Financial Obligations and Human Rights*, 9 May 2023, <https://www.amnesty.org/en/documents/ior40/6756/2023/en/> and *Recommendations to states to finance economic, social and climate justice*, 5 June 2023, previously cited

Хэрэв өрийн бүтцийг өөрчилж, шаардлагатай тохиолдолд цуцлахгүй⁷ бол шинэ санхүүжилтийг (хөнгөлөлттэй хүүтэй байсан ч) одоогийн зээлдүүлэгчдэд өр төлбөрөө төлөхөд зарцуулж, үр дүнд нь уур амьсгалын хямралыг шийдвэрлэх зорилгоор бүрэн дүүрэн ашиглах боломжгүй болно.

Хүний эрхэд нийцсэн өөрчлөлт нь зөвхөн өрийн бүтцийг өөрчлөх, шаардлагатай тохиолдолд өрийг цуцлахаас гадна өрийн хямралын үндсэн шалтгаанууд болох хөгжиж буй орнуудад зээл авахад тулгардаг өндөр зардал, буцалтгүй тусламж дэмжлэгийн дутмаг байдал, их хэмжээний татвараас зайлсхийсэн, зугтсан зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэнэ. Татвараас зайлсхийх, зугтах үйлдлийн улмаас улс орнууд жил бүр 480 тэрбум ам.доллар алдаж байгаа бөгөөд дараагийн арван жилийн хугацаанд энэ хэмжээ 5 их наяд ам.долларын алдагдалд хүрнэ хэмээн тооцоолсон байна.⁸

ЗӨВЛӨМЖ

- Шударга шилжилтийн нөлөөлөлд өртсөн ажилтнууд, тэдний орон нутгийн олон нийт болон бусад хүмүүст зохих дэмжлэг үзүүлэх боломжийг хязгаарлах тогтворгүй өрийн өсөлтөөс урьдчилан сэргийлэхийн тулд уур амьсгалын санхүүжилтийг зээл бус буцалтгүй тусламж хэлбэрээр хангалттай хэмжээгээр санхүүжилт олгох шардлагатай. Өрийн хямралд орсон, эсхүл ийм эрсдэлд орсон улс орнуудын өрийг цаг тухайд нь хөнгөлөх, өрийн бүтцийн өөрчлөлт болон/эсвэл цуцлах зэрэг бүх хувилбарыг задлан шинжилж авч үзэх.
- Хоёр талт, олон талт болон хувийн зээлдүүлэгчдийн хоорондын уялдааг сайжруулах, өрийн хямралд орсон, эсхүл ийм эрсдэлтэй улс орнуудад өрийн хөнгөлөлт үзүүлэх, Үүнд:
 - Өрийн зохицуулалтын талаарх Их 20 (G20)-ийн Нийтлэг тогтолцоог шинэчлэх, үүнд үйл явцыг илүү үр дүнтэй, ил тод, хүртээмжтэй, цаг алдалгүй хэрэгжүүлэх
 - Илүү олон улс өрийн хөнгөлөлтөд хамрагдах, өрийн бүтцийн өөрчлөлт, хөнгөлөх үйл ажиллагаанд илүү олон зээлдүүлэгч оролцох баталгааг хангах.
 - Цаг уурын ноцтой үзэгдэл, уур амьсгалын давагдашгүй хүчин зүйл зэрэг бусад гамшиг болон эдийн засгийн хямралын үед зээлийн төлбөрийг түр зогсоох зохицуулалтыг зээлийн гэрээнд тусгах алхам хийх
 - Өрийн гэрээнд засгийн газрууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтийг хангах, түүний дотор шударга шилжилтийн нөлөөлөлд өртсөн ажилтнууд болон тэдний бүлэгт дэмжлэг үзүүлэхтэй холбоотой төрийн үүргээ биелүүлэх боломжийг сулруулах нөхцлийг тусгахаас татгалзах.
 - Хоёр талт, олон талт болон хувийн зээлийн гэрээний нөхцөлийг ил тод, олон нийтийн хяналтад байлгах боломжийг баталгаажуулах.

⁷ An independent debt work-out mechanism to replace the G20 Common Framework for Debt Treatment - an agreement of the G20 and Paris Club countries to coordinate and cooperate on debt treatments for up to 73 low-income countries - which has proved inadequate, is needed for ESCR realization. To date only four countries have applied for debt treatment under the Common Framework since it was set up in 2020 and only two (Chad and Zambia) have successfully received debt treatment. See for example, Livia Hinz, Florence School of Banking & Finance, *Sovereign debt restructuring and the G20 Common Framework: real or symbolic progress?* 15 July 2024, <https://fbf.eui.eu/sovereign-debt-restructuring-and-the-g20-common-framework-real-or-symbolic-progress/>

⁸ Tax Justice Network, *The State of Tax Justice 2023*, 25 July 2023, <https://taxjustice.net/reports/the-state-of-tax-justice-2023/>

2.2 БОХИДУУЛСАН НЬ ТӨЛӨХ ЗАРЧИМ, ТҮҮНИЙГ ДЭВШИЛТТЭЙГЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Бүхий л салбарт шударга шилжилтийг хэрэгжүүлэхэд ихээхэн хэмжээний санхүү, нөөц шаардлагатай ч, энэ санхүүжилтэд хамгийн их хувь нэмэр оруулах ёстой нь хүлэмжийн хийн ялгаруулалт болон чулуужсан түлшний бохирдолд гол хувь нэмэр оруулдаг улс орнууд, компаниуд болон хувь хүмүүс (тээвэр, агаарын тээвэр, чулуужсан түлш олборлох үйл ажиллагаа эрхэлдэг байгуулага хүмүүсийг оролцуулан) юм. Гэсэн хэдий ч, бохирдуулагч төлөх зарчимд суурилсан олон улсын болон үндэсний татвар хураамжийн тогтолцоо нь нэмэлт санхүүжилт бий болгоход чиглэхийн зэрэгцээ тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн байх ёстой.⁹

ЗӨВЛӨМЖ

- Нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах, бүх салбарт чулуужсан түлшнээс шударгаар шилжих үйл явцыг татварын урамшуулал болон татаасаар дэмжих, уур амьсгалын өөрчлөлтөд өртсөн хүмүүсийг хамгаалахын тулд уур амьсгалын хохирлын прогрессив татвар зэрэг шинэ тогтолцоог бий болгох шаардлагатай.¹⁰ Энэхүү тогтолцоо нь шилжилтийн үед ажилтнуудыг дэмжих, мөн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гарз, хохирлыг нөхөн төлөх санхүүжилтийг багтаах ёстой. Уур амьсгалтай холбоотой шинэ татвар эсвэл татаас тогтоохын өмнө хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг заавал үнэлэх шаардлагатай. Ингэснээр бага орлоготой иргэдэд илүү сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлж, шаардлагатай тохиолдолд зохих нийгмийн хамгааллын механизм (жишээ нь нөхөн олговор, татаас) нэвтрүүлэх боломж бүрдэнэ. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой татварыг шийдвэрлэхдээ чулуужсан түлшний үйлдвэрлэлээс ашиг хүртэгч корпорациуд болон чинээлэг хэрэглэгчдэд нэн тэргүүнд чиглүүлэхийн зэрэгцээ, чулуужсан түлшний үйлдвэрлэлд үзүүлдэг татварын хөнгөлөлт, бусад төрлийн татаасыг зогсоох шаардлагатай.

2.3 ДАЯН ДЭЛХИЙН ТАТВАРЫН КОНВЕНЦИЙГ ДЭМЖИХ НЬ

Дэлхийн татварын хамтын ажиллагаа нь улс орнууд хүний эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлэх баталгааг хангахад чухал үүрэгтэй.¹¹ Санхүүгийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, олон улсын татварын шударга дүрэм тогтоох зорилгоор 2022 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолд дурдсан НҮБ-ын Олон улсын Татварын Хамтын ажиллагааны тухай конвенц нь олон улсын татварын хамтын ажиллагааны хүртээмж, үр нөлөөг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.¹²

НҮБ-ын Татварын конвенцийг бий болгох үйл явцын хүрээнд¹³ хөгжиж буй орнуудын орлого төвлөрүүлэх чадамжийг хязгаарлаж буй татвараас зайлсхийх, татвараас зугтаах, хууль бус

⁹ This means putting the burden primarily on fossil fuel corporations and other high-emitting sectors, for example by increased taxation of their profits or through reducing or eliminating harmful tax expenditures and financing (or investments) availed to them and taxes on wealthier consumers while protecting low-income individuals and groups from regressive impacts through social protection measures, grants and tax exemptions and reforms and by ensuring their access to affordable renewable energy.

¹⁰ See for example Stamp out Poverty, *The Climate Damages Tax A guide to what it is and how it works*, April 2024, https://www.greenpeace.org.uk/wp-content/uploads/2024/04/CDT_guide_2024_FINAL-1.pdf

¹¹ See for example, Amnesty International, *What's Tax Got to Do with It: A Resource Guide on Tax and Human Rights*, 17 September 2024, Index: POL 30/8134/2024, <https://www.amnesty.org/en/documents/pol30/8134/2024/en/>

¹² 5 See Amnesty International, *Promotion of Inclusive and Effective Tax Cooperation at the United Nations: Submission to the UN Secretary General 78th General Assembly Session*, 5-19 September 2023, 17 March 2023, <https://www.amnesty.org/en/documents/ior40/6565/2023/en/>

¹³ For more information on the interlinkages between human rights and the proposed UN Tax Convention, see *Joint civil society and trade unions submission in response to the call for inputs to the work of the Ad Hoc Committee to Draft Terms of Reference for a United Nations Framework Convention on International Tax Cooperation*, 15 March 2024, available at <https://www.amnesty.org/en/documents/ior40/7853/2024/en/>

санхүүгийн урсгалыг бууруулах, урьдчилан сэргийлэх олон арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой бөгөөд ингэснээр санхүүгийн урсгалыг уур амьсгалын болон хөгжлийн зорилтууд, тэр дундаа шударга шилжилттэй нийцүүлэн чиглүүлэх боломж бүрдэнэ.¹⁴

ЗӨВЛӨМЖ

НҮБ-ын Олон улсын татварын хамтын ажиллагааны талаарх суурь конвенцийг баталгаажуулахдаа дараах зүйлсийг хангах хэрэгтэй. Үүнд:

- Ялангуяа бага орлоготой улс орнуудад хүний эрхийг хангахын тулд дотоодын нөөцийн бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор хууль бус санхүүгийн урсгал (IFFs) болон хэт давамгайл, түрэмгий татвараас зайлсхийх зэрэг арилжааны практикийг цогц байдлаар шийдвэрлэх.
- Хүний эрхийн хууль, хэм хэмжээнд тулгуурласан үр дүнтэй санхүүгийн практик, бодлогыг уялдуулахад чиглэсэн, шударга, ил тод, хариуцлагын тогтолцоотой дэлхийн татварын засаглалын бүтцийг бий болгох, түүний дотор бүх гишүүн улс орнуудын тэгш төлөөлөл бүхий Засгийн газар хоорондын НҮБ-ын Татварын комисс байгуулах

2.4 ШУДАРГА ШИЛЖИЛТИЙН ЯВЦАД АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ХАМГААЛАХ ДЭЛХИЙН САН, БҮХ НИЙТИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЭРЭГЦЭЭ

Нийгмийн хамгаалал нь ялангуяа шилжилтийн үеийн гэнэтийн цочролд өртсөн хүмүүст урьдчилан таамаглах буюу тогтвортой байдлыг хангах боломжийг олгодог. Үүнд ялангуяа гэнэтийн цочролд хариу үйлдэл үзүүлэх арга хэмжээ багтдаг бөгөөд энэ нь хямралд өртсөн нийгмийн бүлгийг бүхэлд нь хамарч, тэдгээрийн хэрэгцээнд нийцүүлэн өргөжүүлэх, өөрчлөх боломжтой байдаг. Ийм арга хэмжээ нь ирээдүйд бий болох цочролоос сэргийлэх, шударга шилжилтэд өртсөн ажилтнууд, тэдний гэр бүл, хамт олныг дахин тэнхрэх, сэргэх боломжийг олгодог.

Гэвч уг асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд нийгмийн хамгаалал нь хангалттай санхүүжүүлэлттэй, бүх нийтийг хамарсан байх нь зайлшгүй чухал. Бага орлоготой улс орнуудад орлогын түвшинд тулгуурласан нарийвчилсан зорилтот хөтөлбөрийн оронд¹⁵ Бүх нийтийн нийгмийн хамгааллын хандлагаар¹⁶ нийгмийн хамгааллын тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай хангалттай, зориулагдсан нөөцийг бүрдүүлэх нь уур амьсгалын цочролд өртөх эрсдэлтэй нийгмийн бүлгийн хүний эрхийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хохирол амссан иргэд, шударга шилжилтийн улмаас нөлөөлөлд өртсөн ажилтнууд, нийгмийн бүлгүүдэд онцгой ач холбогдолтой. Нийгмийн хамгааллын давхаргууд (Social Protection Floors) буюу үндэсний хэмжээнд тодорхойлогдсон нийгмийн хамгааллын баталгаа нь амьдралын мөчлөгийн туршид

¹⁴ For example, there are specific references in the Terms of Reference for the UN Framework Convention on International Tax Cooperation to fairly taxing wealthy individuals and corporations, addressing tax avoidance, tax evasion, illicit financial flows, and the allocation of taxing rights among countries - namely the right of a sovereign state to determine the amount of tax that can be applied to a taxpayer's income or wealth. In turn, this will enable governments to have more money to spend on essential goods and services, including support for a just transition of the workforce. See Amnesty International, *Historic Breakthrough In UN Tax Convention Negotiations Ensures Human Rights Will Not Be Forgotten*, 22 August 2024, <https://www.amnesty.org/en/documents/ior40/8448/2024/en/>

¹⁵ Poverty targeting is a commonly used method by states to channel social assistance to groups deemed to be living in poverty or extreme poverty. However, this system faces significant criticism, as when put into practice, targeting based on narrow indicators of poverty often excludes people who should actually be covered, stigmatizes recipients, and involves higher administrative costs. For more information see Amnesty International, *Actions Speak Louder than Words: The World Bank Must Promote Universal Social Protection*, 10 October 2023, <https://www.amnesty.org/en/documents/pol40/7224/2023/en/>

¹⁶ USP refers to an integrated set of policies and programmes that provide equitable access to all people and protect them throughout their lives against poverty and risks to their livelihoods and well-being. This includes benefits for all who need them such as essential health care; child benefits; support for people of working age in case of maternity/paternity, disability, work injury or for those without jobs; and pensions.

тусламж хэрэгтэй байгаа бүх хүмүүст зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, орлогын үндсэн баталгааг хангах¹⁷ боломжийг олгож, Бүх нийтийн нийгмийн хамгаалалд хүрэх чухал арга зам болдог.

Санал болгож буй дэлхийн механизм¹⁸ болох Нийгмийн хамгааллын Дэлхийн Сан¹⁹ нь ялангуяа гамшигт өртөмтгий, төрөлжсөн эдийн засаггүй бага орлоготой улс орнуудад эдийн засгийн шилжилтийн үед улам даамжирч болзошгүй уур амьсгалын нөлөөллөөс үүдсэн үйл явдал, санхүүгийн хямрал зэрэг нөхцөлд зайлшгүй шаардлагатай дэмжлэгийг үзүүлэхэд чиглэнэ. Эдгээр улс орнуудад төсвийн орлого буурахтай зэрэгцэн нийгмийн хамгааллын хэрэгцээ байнга өсөн нэмэгддэг. Ийм нөхцөлд дэлхийн хэмжээний механизм нь үндэсний нийгмийн хамгааллын тогтолцоонд үзүүлэх дэмжлэгийн түвшинг нэмэгдүүлэх боломжтой.

ЗӨВЛӨМЖ

- Шударга шилжилтийн бүхий л бодлого, хөтөлбөр нь нийгмийн хамгааллын одоо байгаа арга хэмжээг бэхжүүлж, нөлөөлөлд өртсөн иргэдэд зохистой хөдөлмөр эрхлэх, шаардлагатай давтан сургалт болон ур чадвараа хөгжүүлэх боломжийг олгосон байх баталгааг хангах
- Нийгмийн хамгааллын зорилт, үзүүлэлтүүдийг Үндэсний тодорхойлолтод шинэчлэн тусгаж, зохистой нийгмийн хамгааллыг бүрдүүлэх замаар уур амьсгалын үйл ажиллагааны зорилтуудыг хэрэгжүүлэх хэрэгцээ, боломжийг тусгах
- Шударга шилжилтийн нөлөөлөлд өртсөн ажилтнууд болон тэдгээрийн нийгмийн бүлгийг амьжиргааны зохистой түвшинд амьдрах эрхийг хамгаалахын тулд нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн санхүүжилт, техникийн дэмжлэгийг нэмэгдүүлэх
- Нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөрүүдийн шинэчлэлийг үндэсний болон бусад улсад үзүүлж буй дэмжлэгийн хүрээнд хэрэгжүүлэхдээ ядуурлыг бууруулахад чиглэсэн явцуу хандлагаас татгалзаж, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц зэрэг засгийн газар хоорондын байгууллагын шийдвэр гаргалтад оролцохдоо бүх нийтийг хамарсан хамгааллыг санал болгож байна.
- Нийгмийн хамгааллын тогтолцоо нь өргөн цар хүрээтэй хямралд дасан зохицсон, цочролд хариу үйлдэл үзүүлэх чадвартай байх баталгааг хангах. Энэ нь байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдлийг одоо байгаа нийгмийн хамгааллын системд нэвтрүүлэх, шинэ систем боловсруулж байх үед уур амьсгалын цочролыг тооцоолох зэргийг багтаасан байх.
- Олон улсын Хөдөлмөрийн байгууллага болон НҮБ-ын Ядуурал ба хүний эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн санал болгосны дагуу Дэлхийн нийгмийн хамгааллын сан байгуулахыг дэмжиж, хангалттай санхүүжилт олгох

¹⁷ 7 ILO Social Protection Floors Recommendation, 2012 (No. 202) states that national social protection floors should include at least four essential guarantees: (a) Access to at least essential healthcare, including maternity care; (b) Basic income security for children, providing access to nutrition, education, care and any other necessary goods and services; (c) Basic income security for persons of working age who are unable to earn sufficient income, in particular in cases of sickness, unemployment, maternity and disability; (d) Basic income security for older persons. ILO commentary on R202 available at: https://www.ilo.org/sites/default/files/wcmsp5/groups/public/@ed_dialogue/@actrav/documents/publication/wcms_743403.pdf

¹⁸ UN Human Rights Council, *Global fund for social protection: international solidarity in the service of poverty eradication: Report of the Special Rapporteur on extreme poverty and human rights, Olivier De Schutter*, 22 April 2021, UN Doc. A/HRC/47/36, <https://www.ohchr.org/en/documents/thematic-reports/ahrc4736-global-fund-social-protection-international-solidarity-service>

¹⁹ Grounded in the principles of international solidarity, the Fund proposal aims to ensure that states receive the necessary technical and financial support to meet their obligations under the right to social security. The Fund will also aim to build the capacity of national social protection systems to scale up their response in case of crises.

2.5 УУР АМЬСГАЛЫН ТЕХНОЛОГИЙН ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА

Шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг хүртэх эрх, түүний хэрэглээ нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактаар баталгаажсан байдаг.²⁰ НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц болон Парисын хэлэлцээрийн дагуу оролцогч талууд технологийн хөгжил, дамжуулалтын чиглэлээр хамтран ажиллах үүрэгтэй,²¹ бөгөөд харин чинээлэг, түүхэн ялгаруулалт өндөртэй улс орнууд бага орлоготой улс орнуудад технологи дамжуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүргийг хүлээдэг.²² Чулуужсан түлшнээс татгалзах шударга шилжилт нь шинэ технологи нэвтрүүлэхийг зайлшгүй шаарддаг. Гэвч хүний эрхэд нийцсэн, үнэнхүү шударга шилжилт байхын тулд энэхүү технологи нь тогтвортой хэрэглээ ба хөгжлийн загварыг дэмжсэн байх ёстой. Энэ хүрээнд нүүрстөрөгчийг тогтоон барих, хадгалах, агаарт шууд барих технологи, нарны болон гео-инженерийн шийдэл зэрэг чулуужсан түлшний хэрэглээг уртасгах эрсдэлтэй, батлагдаагүй, туршигдаагүй шийдэл байх ёсгүй.²³ Ийм төрлийн технологиуд нь хүний эрх байгаль орчинд өндөр эрсдэл учруулж болзошгүй юм.^{24, 25, 26}

ЗӨВЛӨМЖ

- Нүүрс, газрын тос, хий зэрэг чулуужсан түлшний үйлдвэрлэл, хэрэглээг хурдан бөгөөд шударгаар зогсоохын оронд тэдгээрийн хэрэглээг үргэлжлүүлэхэд чиглэсэн бүх төрлийн технологид үзүүлж буй зээл, татаас, татварын хөнгөлөлт, урамшуулал болон бусад санхүүгийн дэмжлэгийг үе шаттайгаар бүрэн зогсоох. Үүнд нүүрстөрөгчийг барих ба хадгалах, нүүрстөрөгчийг шууд зайлуулах, мөн нарны болон газрын инженерчлэлийн технологиуд зэрэг орно.
- 2010 оноос хэрэгжиж буй Биологийн олон янз байдлын конвенцийн хүрээнд бүх хэлбэрийн гео-инженерчлэлд тавьсан де-факто мораториумыг хадгалах, хэрэгжүүлэх, бэхжүүлэх

2.6 ОЮУНЫ ӨМЧ, ХУДАЛДАА, ХҮНИЙ ЭРХ

Технологи дамжуулах үзэл баримтлалын талаарх НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц болон Дэлхийн Худалдааны Байгууллагын (ДХБ) хандлагын зөрчлийн улмаас шударга шилжилтийн хэрэгжилтийг тодорхой аюул оруулж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц нь улс орнуудын ялгаатай үүрэг хариуцлага болон уур амьсгалын технологид хандах

²⁰ Article 15 (b) of the ICESCR.

²¹ Article 1 (c) of the UNFCCC and Article 10 of the Paris Agreement

²² Article 4.3 of the UNFCCC

²³ A de facto moratorium on geo-engineering has been in place since 2010 under the Convention on Biodiversity. See for example, Joint Press Release, *Civil Society Calls for a Stop to Geoengineering our Oceans*, 30 May 2024, available at: <https://www.geoengineeringmonitor.org/2024/05/marine-geo-statement-pr/>

²⁴ Center for International Environmental Law, "Carbon Capture and Storage (CCS): Frequently asked questions", 26 April 2023, <https://www.ciel.org/reports/carbon-capture-and-storage-frequently-asked-questions/>; P. Gunther and P. Ekaradt, Human Rights and Large- Scale Carbon Dioxide Removal: Potential Limits to BECCS and DACCS Deployment, Land, 2022, Vol 11, Issue 12, <https://www.mdpi.com/2073-445X/11/12/2153>

²⁵ The UN Special Rapporteur on the implications for human rights of the environmentally sound management and disposal of hazardous substances and wastes has highlighted the risks posed by these technologies, including the health and safety risks of CCS solutions whilst locking in place fossil fuel-reliance and the associated environmental injustices. See Human Rights Council Fifty-fourth session, *The toxic impacts of some proposed climate change solutions Report of the Special Rapporteur on the implications for human rights of the environmentally sound management and disposal of hazardous substances and wastes*, Marcos Orellana, UN Doc. A/HRC/54/25, 13 July 2023, para. 70

²⁶ The UN Human Rights Council Advisory Committee has also underscored that, at present, the development of any new technologies intended for climate protection, including direct carbon removal and solar geoengineering, and policies to support them "would not be in accordance with the protective standards of the human rights regime". UN Human Rights Council 54th session, *Impact of new technologies intended for climate protection on the enjoyment of human rights: Report of the Human Rights Council Advisory Committee*, UN Doc. A/HRC/54/47, 10 August 2023, para 66

харилцан адилгүй хандлагыг онцолдог бол, харин ДХБ нь оюуны өмчийн эрхийг багтаасан тэгш байдал ба чөлөөт худалдааны зарчимд тулгуурладаг.²⁷

Оюуны өмчийн эрх нь шинжлэх ухаан, технологийн хөгжил болон түүний үр шимийг хүртэх боломжид олон талаас сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тул улс орнууд эдгээр сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах зохистой арга хэмжээг авах шаардлагатай.²⁸

Үр дүнтэй, амбицтай шударга шилжилтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тогтвортой технологийн дамжуулалтыг саатуулах зорилгоор оюуны өмчийн эрхийг ашиглах ёсгүй.²⁹ Уур амьсгалын өөрчлөлтийн дэлхийн сорилтыг хамтад нь шийдвэрлэхийн тулд системтэй хариу арга хэмжээ авах ёстой ба ийм төрлийн технологид оюуны өмчийн эрхийн хамгаалалт үйлчлэхгүй байх шаардлагатай.

ДХБ-ын Худалдаатай холбоотой оюуны өмчийн эрхийн тухай (TRIPS) хэлэлцээрийн хүрээнд олгогдсон уян хатан зохицуулалт нь энэ төрлийн бэрхшээлийг даван туулахаад хангалтгүй байх өндөр магадлалтай. Учир нь эдгээр зохицуулалт нь улс орон бүрийн нөхцөл байдалд тулгуурлан хэрэгждэг бөгөөд КОВИД-19-тэй холбоотой эм хэрэгслийн оюуны өмчийн эрхийн жишээ нь бага орлоготой орнуудын хувьд ийм уян хатан зохицуулалтыг бодитоор ашиглахад олон саад бэрхшээл байгааг харуулсан. Ийм нөхцөл байдал нь эдийн засаг, нийгмийн эрхүүд, тухайлбал амьд явах, эрүүл мэнд байх, тогтвортой хөгжих, цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах зэрэг хүний үндсэн эрхүүд зөрчигдөхөд хүргэх эрсдэлтэй.

1.1.1 ЗӨВЛӨМЖ

- Уур амьсгалын технологийг шилжүүлэхэд тулгарч буй худалдааны саад бэрхшээлийг дараах арга замаар шийдвэрлэх шаардлагатай. Үүнд:
 - Оюуны өмчийн эрх, мэдлэг болон технологи дамжуулах үйл явц нь нэвтрэхэд саад болохооргүй байхаар дэлхийн худалдааны дүрмийг өөрчлөх;
 - Уур амьсгалын технологийн дамжуулалт хурдан, шударга явагдах нөхцөлийг хангахын тулд улс орнуудын оюуны өмчийн тухай хууль, бодлого, хэрэгжилтийн практикт шаардлагатай өөрчлөлтүүдийг тодорхойлж, хэрэгжүүлэх. Ингэснээр бага болон дунд орлоготой улс орнуудын өндөр орлоготой улс орнууд болон тэдгээрийн уур амьсгалын технологийн компаниудаас хамааралтай байдлыг бууруулах.
- Шаардлагатай уур амьсгалын технологийн дамжуулалт нь тухайн технологийг хүлээн авч буй улс орнуудын институцийн болон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, улмаар ажиллах хүчийг уг технологийг ашиглахад шаардлагатай ур чадвараар хангаж, зохистой хөдөлмөр эрхлэх эрхээ бүрэн эдлэх боломжийг бүрдүүлэх ёстой.

²⁷ Robert Burrell, Su Jung Jee, Kerstin Hütte and Caoimhe Ring, Institute for New Economic Thinking, *Intellectual Property Rights, Climate Technology Transfer and Innovation in Developing Countries*, INET Oxford Working Paper No. 2023-14, August 2023, p52, <https://www.inet.ox.ac.uk/files/intellectual-property-rights-2023-14.pdf>

²⁸ See for example CESCR, *General Comment 25, (2020) on science and economic, social and cultural rights (article 15 (1) (b), (2), (3) and (4) of the International Covenant on Economic, Social and Cultural Rights)*, UN Doc. E/C.12/GC/25, 30 April 2020, <https://undocs.org/E/C.12/GC/25>

²⁹ Suma Athreye and others, *Intellectual property rights and the international transfer of climate change mitigating technologies*, Research Policy, Volume 52, Issue 9, November 2023

ХАВСРАЛТ: ШУДАРГА ШИЛЖИЛТИЙГ ШАЛГАХ ХУУДАС

Эмнести Интернэшнлээс боловсруулав

Энэхүү шалгах хуудас нь хэрэглэгчдэд хууль, бодлого, практикийг цогцоор нь үнэлэх боломж олгохын зэрэгцээ PANEL аргачлалыг ашигласан. Уг аргачлал нь олон улсын болон засгийн газар хоорондын үйл явцыг үнэлэхэд өргөн хэрэглэгддэг бөгөөд хүний эрхийн суурь дараах зарчмуудыг баримталдаг. Үүнд: Оролцоо, Хариуцлага, Үл ялгаварлалт ба тэгш байдал, Чадавхжуулалт, Хууль ёсны байдал

ОРОЛЦОО — хүмүүс өөрсдийн эрхэд нөлөөлөх шийдвэр гаргалтад оролцох ёстой.

ХАРИУЦЛАГА — хүний эрх хэрхэн хангагдаж байгаа, түүнчлэн хүний эрхийн зөрчлийг хэрхэн шийдвэрлэж байгаа асуудлаар мониторинг хийх

ҮЛ ЯЛГАВАРЛАЛ БА ТЭГШ БАЙДАЛ — Бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглох, урьдчилан сэргийлэх, арилгах. Эрхээ эдлэхэд нь хамгийн их саад бэрхшээлтэй тулгарч буй нийгмийн бүлгийг тэргүүн ээлжид анхаарах

ЧАДАВХИЖУУЛАЛТ — Хүн бүр өөрийн эрхээ ойлгож, амьдралд нь нөлөөлөх бодлого, практикийг боловсруулах үйл явцад бүрэн дэмжлэг авч оролцох боломжтой байх.

ХУУЛЬ ЁСНЫ БАЙДАЛ — Хандлага, арга барил нь дотоодын, бүс нутгийн болон олон улсын хууль тогтоомжид заасан хууль ёсны эрхэд тулгуурласан байх.

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ			
	ХУУЛЬ	БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨ	ПРАКТИК
Төр нь чулуужсан түлш үйлдвэрлэлийн салбарын ажилтнуудыг өөр ажил хөдөлмөр эрхлэх боломжийг олж авахад дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөтэй байх			
Төр нь шилжилтийн явцад ажилтнууд болон бүлгийг дэмжихэд хангалттай нөөцийг хуваарилсан байх			
Төр нь чулуужсан түлшний салбарт хамааралтай бүлэгт орлогын өөр хувилбар олж авахад дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөтэй байх			
Төр нь бага орлоготой иргэд болон нийгмийн эмзэг бүлгүүдийг шилжилтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах тодорхой бодлоготой байх.			
Бодлого, төлөвлөлт нь улс орнуудын олон улсын хүний эрхийн үүрэг, бизнесийн байгууллагуудын хүний эрхийн хариуцлагатай нийцсэн байх. ³⁰			

³⁰ For business' human rights responsibilities see [GuidingPrinciplesBusinessHR_EN.pdf \(ohchr.org\)](#) and [Guidelines for multinational enterprises - OECD](#)

ОРОЛЦОО			
Хүмүүс өөрсдийн эрхэд нөлөөлөх шийдвэр гаргалтад оролцох ёстой			
	ХУУЛЬ	БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨ	ПРАКТИК
Тодорхой бүлгүүдийг тодорхойлж, тэдгээрт чиглэсэн тусгай бодлого, төлөвлөгөө, үйл явцыг хэрэгжүүлдэг байх. ³¹			
Нийгмийн яриа хэлэлцээ нь шударга шилжилтийн бодлого боловсруулах, төлөвлөх, эрсдлийг тодорхойлох, бууруулах, хэрэгжүүлэх болон бүх түвшний шийдвэр гаргалтад үнэлгээ хийх үйл явцад институцийн бүтэц дэх зайлшгүй чухал хэсэг байх.			
Нийгмийн хэлэлцээний хүрээнд шударга шилжилтийн бодлогын үйл явцын бүх боломжит шат, түвшинд нийгмийн түншүүд оролцох боломжийг олгодог.			
Шударга шилжилтийн бүх үйл явцын туршид холбогдох бүх талууд, түүний дотор нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн зохистой, мэдээлэлтэйгээр, тасралтгүй зөвлөлдөх үйл явцыг хэрэгжүүлэх. ³²			
Нутгийн уугуул хүмүүстэй зөвлөлдөх үйл явц нь тэдний зан заншил, уламжлалыг хүндэтгэсэн, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхагдахаас сэргийлдэг. Зөвлөлдөөн нь чөлөөтэй, урьдчилсан, мэдээлэлтэй, зөвшөөрөлд үндэслэгддэг.			
Нийгмийн яриа хэлэлцээнд саад учруулахгүй байх, тухайлбал төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс хүний эрхийн хамгаалагчид, үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн эсрэг дарамт, халдлага гарахгүй байх			

³¹ For example:

- Marginalized groups including socially and economically disadvantaged and those facing discrimination on multiple and intersecting grounds
- Groups most affected by transition decisions and actions
- Workers and their representatives
- Indigenous people
- Human rights defenders

³² “Adequate” includes appropriate mechanisms to facilitate consultation and participation of all those affected whilst adopting a gender-based and intersectional approach. It also involves an analysis of existing formal and informal structures of participation and organization at the local and national level in order to understand processes that may facilitate or hinder the participation of those different groups, and to develop, where needed, a targeted strategy and specific measures to ensure their effective access to information, participation, consultation and, if appropriate, free, prior and informed consent.

ХАРИУЦЛАГА

Хүний эрх хэрхэн зөрчигдөж буйг болон түүнчлэн хүний эрхийн зөрчил гарсан тохиолдолд нөхөн олговор болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлж байгааг хянах.

	ХУУЛЬ	БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨ	ПРАКТИК
Шударга шилжилтийн бүх арга хэмжээг төслийн хэрэгжилтийн бүх шатанд буюу урт хугацаанд үр дүнтэйгээр хянаж, үнэлэх үүргийг төрөөс хараат бус тусгай байгууллагууд гүйцэтгэдэг. Үүнд, парламентын, захиргааны болон хагас шүүхийн шинжтэй байгууллагууд багтаж болно.			
Тр, хувийн хэвшлийн бүхий л оролцогчийн явц, ахиц дэвшилд мониторинг хийхийн тулд хүний эрхэд нийцсэн шалгуур үзүүлэлт, стандарт, зорилтуудыг боловсруулж, хэрэгжүүлэх. Энэ нь хүйс, үндэс угсаа, харьяалал, бэлгийн чиг баримжаа зэрэг ялгаварлан гадуурхлын үндсэн шинжээр нарийвчлан ангилагдсан байх.			
Шударга шилжилтийн үйл явцын бүх үе шатанд хохирсон хүмүүст нөхөн олговор олгох зэргээр зөрчигдсөн эрхийг сэргээх зохистой арга хэмжээ авах			
Зөрчигдсөн эрхийг үр дүнтэй сэргээх захиргааны болон шүүхийн зохистой хариуцлагын механизмаар хангадаг байх ³³			
Шударга шилжилттэй холбоотой төсөл, үйл ажиллагаанд оролцож байгаа хувийн хэвшлийн оролцогчдын үйл ажиллагааг зохистой, үр дүнтэйгээр зохицуулдаг байх			
Хүний эрх хамгаалагчид (HRDs) мэдээллийг цаг тухайд нь авах боломжтой байхаас гадна мэдээлэх тогтолцоо нь Хүний эрхийн хамгаалагчдад хүртээмжтэй байх. (хүний эрх хамгаалагчид шүгэл үлээгчийг хамааруулан авч үзнэ)			
Хариуцлага нь бусад улс орнуудад, тухайлбал, ашигт малтмалын нөөцөөр дамжуулан нөлөөлөлд өртсөн хүмүүст ч нэгэн адил хамаарна.			

³³ Accountability mechanisms could include National Contact Points (NCPs) – OECD Watch

ҮЛ ЯЛГАВАРЛАЛ, ТЭГШ БАЙДАЛ

Бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглох, урьдчилан сэргийлэх, арилгах. Эрхээ эдлэхэд нь хамгийн их саад бэрхшээлтэй тулгарч буй нийгмийн бүлгийг тэргүүн ээлжид анхаарах

	ХУУЛЬ	БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨ	ПРАКТИК
Шударга шилжилтийн бодлого, хөтөлбөр нь уг шилжилтийн сорилт бэрхшээл болон боломжуудыг хүйсийн тэнцвэрийн талаас авч үздэг. Тэгш байдлыг дэмжихийн тулд жендерийн тодорхой бодлого боловсруулж, хэрэгжүүлж, хянаж, тогтмол үнэлэх.			
Шударга шилжилтийн бодлого, хөтөлбөр нь нийгмийн давхарга, үндэс угсаа, нас, хөгжлийн бэрхшээл зэрэг тэгш бус байдал, ялгаварлан гадуурхлын талаас авч үздэг ба олон хүчин зүйлсийн, огтлолцсон нөлөөг харгалзан үздэг. Эдгээрт, уугуул иргэд, үндэстний цөөнх зэрэг эмзэг бүлэгт үзүүлэх нөлөөлөл хамаарна. Шударга үр дүнд хүрэхийн тулд тухайн бүлгүүдэд тодорхой бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.			
Ялгаварлан гадуурхлын үндсэн шинжээр ангилсан нарийвчилсан мэдээллийг цуглуулж, хянаж, хүний эрхийн зарчимд нийцүүлэн JT бодлого, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд ашигладаг. Үүнд уламжлалт мэдээлэл цуглуулах аргуудаас гадна оролцооны үндсэн дээр мэдээлэл цуглуулах аргуудыг ашигладаг.			

ЧАДАВХИЖУУЛАЛТ

Хүн бүр эрхээ ойлгож, амьдралд нь нөлөөлөх бодлого, үйл ажиллагааг боловсруулахад оролцоход бүрэн дэмжлэг үзүүлдэг байх.

	ХУУЛЬ	БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨ	ПРАКТИК
Ажилтнууд болон олон нийтэд шударга шилжилтийн хүрээ, тогтвортой хөгжил, зохистой хөдөлмөр, ногоон ажлын байртай холбоотой шинэчлэл, мэдээллийг таниулах, ойлголтыг нэмэгдүүлж, заавар зөвлөмжөөр хангах			
Нөлөөлөлд өртсөн ажилтнууд болон нийгмийн бүлэгт өөрсдийн эрх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрхийн талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх			

ХУУЛЬ ЁСНЫ БАЙДАЛ

Хандлага, арга барил нь дотоодын, бүс нутгийн болон олон улсын хууль тогтоомжид заасан хууль ёсны эрхэд тулгуурласан байх.

	ХУУЛЬ	БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨ	ПРАКТИК
Бодлого, төлөвлөгөө нь хүний эрхийн үндсэн зарчмууд хүндэтгэж, дэмжиж, хэрэгжүүлэх ёстой ба холбогдох хувь хүний эрхийг хамгаалах шаардлагатай.			
Шударга шилжилтийн хүрээнд хамгийн холбогдолтой олон улсын хүний эрх, хөдөлмөрийн хууль, стандартыг дэмжиж, холбогдох конвенцуудын хувьд тэдгээрийг батлан хэрэгжүүлэх, бүрэн мөрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулах. Шударга шилжилтийн хүрээнд хамгийн их хамааралтай олон улсын хүний эрхийн хууль, хөдөлмөрийн хууль, хэм хэмжээг сурталчлах, холбогдох олон улсын гэрээний тухайд тэдгээрийг соёрхон батлах, бүрэн хэрэгжүүлэхэд чиглүүлэх ³⁴			

³⁴ Relevant international law includes the [UN International Covenant on Economic, Social and Cultural Rights](#); the [UN International Covenant on Civil and Political Rights](#); various [ILO Conventions relating to workers' rights](#). Relevant standards include [UN CESCR General Comments](#)

Эмнести Интернэшнл бол хүн бүрд эрхийг нь эдлүүлэхийн төлөө хүмүүсийн хүнлэг сэтгэлд тулгуурлан кампанит ажил өрнүүлдэг 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн дэлхий даяарх хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөн юм.

Эрх мэдэлтнүүд нь олон улсын эрх зүйг хүндэтгэж, үүрэг амлалтаа биелүүлдэг, хариуцлага хүлээдэг дэлхий ертөнцийг бий болгох нь бидний зорилго.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл, эдийн засгийн ашиг сонирхол, шашны үзлээс хараат бус бөгөөд гишүүд, дэмжигчдийн хандив, дэмжлэгээр санхүүждэг.

Эв санааны нэгдэл, хүнлэг энэрэнгүй хүмүүсийн үйлдэл нь илүү сайхан нийгмийн өөрчлөлтийг бий болгож чадна гэдэгт бид итгэдэг.

Contact


info@amnesty.org


[facebook.com/
AmnestyGlobal](https://facebook.com/AmnestyGlobal)


[@Amnesty](https://twitter.com/Amnesty)


amnesty.org



Amnesty International
Peter Benenson House
1 Easton Street
London WC1X 0DW, UK

Өөрөөр заагаагүй бол энэхүү баримт бичигт агуулагдах контентыг Creative Commons (атрибут, арилжааны бус, олон улсын 4.0) лицензийн эрхээр хамгаалсан.
(creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode-г үзнэ үү)

Хэрэв материал нь Эмнести Интернэшнлээс өөр зохиогчийн эрх эзэмшигчтэй холбоотой бол энэ материал нь Creative Commons лицензэд хамаарахгүй.

Дэлгэрэнгүй мэдээллийг Эмнести Интернэшнлийн вэб сайтын зөвшөөрлийн хуудаснаас авна уу.

Index: **IOR 40/8827/2024**

Publication: **December 2024**

Original language: **English**

© Amnesty International 2024

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**

